



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2014 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 42

Мандалговь

Хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 77.3 заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 5 дугаар зүйлийн 5.2.2, 5.2.4, 5.8.г дэх заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. "Дундговь-Ус" ОНӨҮГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 1,400,000 /нэг сая дөрвөн зуун мянган/ төгрөгний анхны өртөгтэй, 1,155,000.33 /нэг сая нэг зуун тавин таван мянган төгрөг гучин гурван мөнгө/-ний хуримтлагдсан элэгдэл бүхий 10-р усан сангийн барилгыг акталж устгахыг зөвшөөрсүгэй.
2. Хөрөнгө актлах ажлыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөл, Орон нутгийн өмчийн газрын хяналтан дор зохион байгуулж, актлагдсан хөрөнгийг зохих хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг "Дундговь-Ус" ОНӨҮГазар /Д.Ганбаатар/-г даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

0100114